

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 5 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 6 дугаар сарын 02-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. Энэ хүрээнд хөтөлбөрийг төслийг танилцуулж, санал авах зорилгоор Соёлын яам, ХХААХҮЯ, БХБЯ, ЭМЯ, ХЗДХЯ болон ХНХЯ-ны Хүн ам, Гэр бүлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын удирдлага, ажилтнуудтай уулзалт зохион байгууллаа. Мөн ЭЗХЯ-наас 2 удаа зохион байгуулсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх семинарт тус хөтөлбөрийг боловсруулах ажлын багийн бүрэлдэхүүн оролцлоо. Семинарын үеэр хөтөлбөрийн төслийг бусад хөтөлбөртэй уялдуулах, давхардал, хийдлийг арилгах, хариуцах салбар байгууллага, хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тодорхойлох чиглэлээр бусад хөтөлбөрийн ажлын хэсэгтэй хамтран ажиллав. Хөтөлбөрийг боловсруулах дэд ажлын хэсгийн хурлаар хөтөлбөрийн төслийг танилцуулан, хөтөлбөрийн төсөлд тусган, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэхээр бэлтгээд байна.			✓	
2.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулж, бүх яамд болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээ.		✓		
3.	Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны санаачлан боловсруулсан Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөлд санал боловсруулж, 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1/1436 дугаар албан бичгээр УИХ-ын гишүүн Ц.Туваанд, 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 1/1463 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд тус тус хүргүүлэв.		✓		
4.	Нийгмийн даатгалын сангийн удирдлага, зохион байгуулалтын асуудлаар ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын асуулгад хариу мэдээлэл бэлтгэж, УИХ-ын НББХ-ны 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэв.		✓		
5.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд гарах зардалтай холбоотой тооцоо судалгааг боловсруулж, Сангийн яамны удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулж, хуулийн төслийг хэлэлцүүлэв.			✓	
6.	Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн судлаачдаас “Нийгмийн даатгалын хууль, тогтоомж”-д хүний эрхийн талаар хийсэн үнэлгээ, судалгаатай танилцаж, хуулийн төсөлд саналыг тусган 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн боловсруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэв.			✓	
7.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн 30 гаруй төлөөлөлд 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдөр, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын төлөөлөлд 2022 оны 5 дугаар сарын 7-ны өдөр, УИХ дахь Олонхийн бүлэгт 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр тус тус танилцуулж, хэлэлцүүлэв.		✓		
8.	Нийгмийн даатгалын шимтгэлийг татварын албаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 20 гаруй удирдлага, албан хаагчдыг оролцуулсан хэлэлцүүлгийг 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав.			✓	

9.	“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийн орос, монгол хэл дээрх орчуулгыг тулган эцэслэн хянаж дуусгав. Оросын талд хүргүүлэх саналыг томъёолж Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтэст хүргүүлэв.			√	
10.	“Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн 16 дугаар зүйлд заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Удирдлагын тохиролцоо”-ны төслийг эцэслэн боловсруулав.			√	
11.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго, хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохион байгуулалт, Ерөнхий сайдын оролцоо болон үр дүн ач холбогдол гэсэн агуулгын хүрээнд танилцуулга РР бэлтгэж Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхүүдэд хүргүүлэв.		√		
12.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хүн амын өсөлтийг дэмжих тухай хуулийн төслийг танилцуулга холбогдох судалгааны хамт санал авахаар шинээр байгуулагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.			√	
13.	Хүнсний эрхийн бичиг болон 2005 оноос хойшхи Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хууль эрх зүй, хамрах хүрээ, олголтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн Сангийн яаманд, нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан эх, хүүхдийн мэдээллийг 9 дүүрэг тус бүрээр гарган Ерөнхийлөгчийн Тамгын газарт гаргаж хүргүүлэв.		√		
14.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын болон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудаас санал авч, эдгээр байгууллагуудын 50 гаруй төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, яамдын саналуудыг нэгтгэн ажиллалаа. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 144 дүгээр зүйлийн 144.5 дахь хэсэгт заасныг үндэслэн “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.			√	
15.	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох асуудлаар Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны хурлын бэлтгэл ажлыг ханган, 5 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулав. ХНТГТҮХ-ны 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг талууд зөвшилцөж, Үндэсний хорооны 10 дугаар тогтоолоор сард 550,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоов.			√	
16.	Нийгмийн даатгалын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллаж байна.			√	
17.	“Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт YAMAT-08”-д хүүхдийн зуслан, хөгжлийн төв, асрамж халамжийн төвийн “Хүүхдийн хөгжлийн арга зүйч” нарыг нэмж оруулах асуудлаар Хүүхдийн хөгжлийн төв, ордон, зуслангийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулав.			√	
18.	ЭАБХУТ НҮБ-ын конвечийн ээлжит 10 дугаар тайланг Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Нэгдсэн Үндэстний байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хороонд хүргүүлсэн ба Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдож, энэ оны 06 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд онлайн хэлбэрээр хэлэлцүүлэхээр тов тогтсон. Тайланг хамгаалахтай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			√	
19.	ХНХ-ын Сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдан хэрэгжиж буй “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-бодлогын болон цахим шинэчлэлийн хүрээнд шинэчлэн боловсруулж, санал авах 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулан, эцэслэн батлуулахаар ажиллаж байна.			√	
20.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/120, А/178 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх” журмыг бодлогын болон цахим шинэчлэлийн хүрээнд шинэчлэн боловсруулж, санал авах 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион			√	

	байгуулан, эцэслэн батлуулахаар ажиллаж байна.				
21.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн санал дээр ажиллаж, хуулийн төсөл болон үзэл баримтлалын төсөлд холбогдох саналуудыг тусган ажиллав.			√	
22.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн хувилбараас өөрчлөгдөж, нэмэгдсэн зүйл, заалтыг түүвэрлэн авч Зардлын тооцоо боловсруулж буй зөвлөхөд хүргүүлэв.			√	
23.	<ul style="list-style-type: none"> Дэд сайдын ахалж буй "Нийгмийн халамжийн бодлого, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд оновчтой хүргэх ажлын хэсэгт танилцуулах хуулийн төслүүдийн танилцуулгыг бэлтгэв. БХБЯ-аас ирүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"-т санал боловсруулж хүргүүллээ. "ХБИ-ийг ажлын байранд дадлагажуулагч бэлтгэх журам"-ын төслийг хэлэлцэж, санал боловсруулав. 			√	
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
24.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/05 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдэд Нийгмийн халамжийн тухай хууль, нийгмийн даатгалын хуулийн төсөл, мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний талаарх бусад улсын туршлагыг судалж танилцууллаа.			√	
25.	"Төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд санал бэлтгэн 2022 оны 5 дугаар сарын 19-ний 01/1381 тоот албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэв.		√		
26.	Европын Холбооны санхүүжилттэй Дэлхийн Банкны "Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд төсөв, санхүүгийн удирдлагын шинэчлэлийн стратеги болон төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендерийн дүн шинжилгээ хийх, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг салбарын яамдад үе шаттай туршин нэвтрүүлэх ажил 2020-2022 онуудад хэрэгжиж байна. 2022 онд Нийгмийн халамжийн салбарын хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээнд жендерийн дүн шинжилгээ хийх, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг турших юм. Энэ хүрээнд Сангийн яамнаас цахимаар зохион байгуулсан 2-3 удаагийн уулзалтад оролцож халамжийн чиглэлээр хөтөлбөрийг сонгох чиглэлээр БТГ-аас танилцуулга хийж, зөвлөхүүдийн зөвлөмжийн дагуу асаргааны тэтгэмжид жендерийн дүн шинжилгээ хийхээр сонгож авсан. Уг сонгосон хөтөлбөр, арга хэмжээний жендерийн дүн шинжилгээнд зориулж хууль эрх зүй, статистик тоо мэдээлэл, хийгдсэн үнэлгээ, судалгааны мэдээллийг хүргүүлж хамтран ажиллаж байна.			√	
27.	"Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилго, Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын уялдааг гаргахаар ажиллаж байна. Бодлогын баримт бичгийн уялдааг гаргаснаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2023-2025 оны төсвийн төлөвлөлтийг оновчтой төсөвлөх, төлөвлөх, хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой юм.			√	
28.	Нийгмийн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Монгол HD телевизтэй хамтран 2 нэвтрүүлэг, 1 ярилцлага хийж гүйцэтгэсэн. Үүнээс эхний ээлжинд бэлэн болсон 1 нэвтрүүлэг, 1 ярилцлагын агуулгыг хянан эцэслэж, 6 дугаар сарын 4, 5-нд эфирээр цацахаар ТВ-ийн хуваарьт орууллаа.			√	

29.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/225, А/60 тоот хамтарсан тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргачлалыг шинэчлэх” ажлын хэсэг байгуулагдсан ажлын хэсэг шинэ аргачлалыг боловсруулан Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлөөр хэлэлцүүлж зөвшөөрсөний дагуу Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/84, А/89 тоот хамтарсан тушаалаар батлуулсан. Аргачлал батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн нэгдсэн мэдээллийн санг удирдах, ашиглах журмыг” шинэчлэн боловсруулахаар Үндэсний статистикийн хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд албан бичгээр ажлын хэсэгт орж ажиллах хүний нэрсийг авч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/106 тоот тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Мөн Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-оос улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцооллыг Азийн хөгжлийн банкинд хүргүүлэхээр болсоны дагуу урьдчилсан байдлаар тооцооллыг агентлагаас хүлээн авч, нэмэлт тооцоолол хийсэн.			√	
30.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/87 дугаар тушаалаар “Нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээний хэрэгжилтийг шалгах аян”-ы хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголт, зарим үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж, сайжруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлав. Тус аяныг яамны ХШҮДАГ болон МХЕГ-тай хамтран зохион байгуулж байна.			√	
31.	Нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, халамжийн үйлчилгээний цахимжуулалт, төсвийн хэмнэлт, иргэдээс ирүүлж буй өргөдөл гомдол г.м. асуудлаар ХХҮЕГ, ННХГ, 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нартай цахим хурал зохион байгуулав.			√	
32.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд “Нийгмийн халамжийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-д Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Дундговь, Архангай, Өвөрхангай, Дархан, Сэлэнгэ болон Төв аймгийн нийгмийн халамжийн мэргэжилтэн болон сумын нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийг хамруулав. Энэхүү сургалтыг 6 дугаар сард багтаан үлдсэн аймгуудад зохион байгуулахаар ажиллаж байна.			√	
33.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд холбогдох газрын саналыг авч байна.			√	
34.	Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдох мэдээллийг бэлтгэн МҮЭХ-нд танилцуулахаар бэлтгэж байна.			√	
35.	-“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/111 дүгээр тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын “Хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжүүлэх чиглэлийг харьяа байгууллагуудад албан бичгээр хүргүүлэв. -“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн зааврыг баталж, байгууллага бүр өөрийн онцлогт нийцүүлэн зааврын дагуу өөрсдийн Хүүхэд хамгааллыг бодлогыг баталж, мөрдөн ажиллах тухай Зөвлөмжийг АОЭНХ, МХАҮТ, МҮЭХ-дод албан бичгээр хүргүүллээ.			√	
36.	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хүүхдийн эрхийн стандартуудын эмхтгэл боловсруулж, Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр 2000 хувь хэвлүүлэн, мэргэжлийн байгууллагын албан хэрэгцээнд түгээв. -Хөтөлбөрт суурилсан төлөвлөлт арга зүйн сургалтын хөтөлбөрийг НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран боловсруулж 6 сарын эхний 7 хоногт сургалт хийх бэлтгэлийг ханган ажиллаж байна. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад тулгарч буй сорилт, бэрхшээл, тэдгээрийн гарц шийдлийг орон нутгийн үүрэг хүлээгч нартай хамтдаа тодорхойлох зорилгоор “Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, хийх ажлын удирдамж” боловсруулав.			√	
37.	-Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы санаачилгаар “Хүүхдэд ээлтэй Монгол” үндэсний чуулганыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,			√	

	<p>НҮБ-ын Хүүхдийн сан, Олон Улсын Хөгжлийн Эрх Зүйн Байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа. Энэхүү чуулганд нийт 650 хүн оролцов.</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд асрамж халамжийн төвүүдэд амьдардаг “2021-2022” онд урлаг, спорт, сурлагын өндөр амжилт гаргасан 43 хүүхдийг хүлээн авч уулзаж, Олон улсын Найрамдал цогцолборт амрах эрхийн бичгээр шагнав.</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Хүүхдийн төлөө сангаас олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож, амжилт гаргасан хүүхдүүдийг урамшуулах нэг удаагийн мөнгөн шагналд 72.900.000 /далан хоёр сая есөн зуун мянга/ төгрөгийг зарцуулахаар батлав.</p>				
38.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн “Хүүхдийн эрх хамгаалах, ээлтэй орчин” салбарын хэлэлцүүлгийг 5-р сарын 3-нд яаман дээр зохион байгуулав. Яам болон харьяа байгууллагын нийт 80 гаруй албан хаагч биетээр, 100 албан хаагч цахимаар холбогдон оролцов.</p>			√	
39.	<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийг дэмжих үйлчилгээний стандартын төслийн хэлэлцүүлгийг 5-р сарын 24-ний өдөр яаман дээр зохион байгуулж, яам, агенлагийн төлөөлөл болон зөвлөхүүд оролцож, гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хийсэн үнэлгээний тайлан болон гэр бүлийг дэмжих үйлчилгээний стандартын төслийг хэлэлцүүлэв. • Гэрлэлт цуцалсаны дараа хүүхдийн эрхийн зөрчил, тэтгэлэг төлөлттэй холбоотой гардаг асуудлын хууль эрх зүйн зохицуулалтын талаар танилцуулга мэдээлэл бэлтгэж удирдлагад өгөв. • Хүүхдийн тэтгэлэг тогтоолт, зохицуулалтын талаар олон улсын туршлага, Монгол Улсын туршлагыг харьцуулан судалж, PPT бэлтгэн тус яамны холбогдох газрын хүрээнд хэлэлцүүлэв. 			√	
40.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэгдсэн мэдээллийн сан байгуулах ажлын хэсгийн хамтарсан тушаал, удирдамжийн төсөл болон хэлэлцүүлгийн хөтөлбөрийг боловсруулж ажлын хэсгийн тушаал гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэв.</p>			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
41.	<p>“Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулахаар яамд болон холбогдох байгууллагаас санал авч тусган боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хэлэлцүүлэхээр хүргүүлэв.</p>		√		
42.	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам батлах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 01/1367 тоот албан бичгээр яамдаас санал авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хэлэлцүүлэхээр хүргүүлэв.</p>		√		
43.	<p>Тэтгэвэр тооцох итгэлцүүрийн хувилбаруудыг тооцон гаргаж танилцуулга, тооцооллын хамт яамны удирдлагуудад танилцуулав.</p>			√	
44.	<p>Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа архивын лавлагааг хуурамчаар үйлдэх, засах зэрэг зөрчлийг арилгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан. Энэхүү ажлын хэсэгт Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Архивын ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөллийг оролцуулан хурлыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хуралдав. Хуралдаанаар ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө, холбогдох бусад судалгаа, мэдээллийг гаргахаар болов.</p>			√	
45.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Шүүхийн сахилгын хороо, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох албаны хүмүүстэй шүүхийн шийдвэрийг хуурамчаар үйлдэх, хуурамч нотлох баримт бичиг бүрдүүлэн өгч шүүхийн шийдвэр гаргуулж байгаа асуудлын талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд шүүгч нар, даатгуулагч, иргэд, ажил олгогчдод зориулсан контентийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран хийхээр болов.</p>			√	

46.	Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын судалгаа, Нийгмийн даатгалын хамралтын судалгаа, Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоон судалгаа, Нийгмийн даатгалын тоон үзүүлэлтүүдийг макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан судалгаа, Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гадаад иргэдийн судалгаа зэрэг 5 судалгаа хийж, товч танилцуулга боловсруулж, удирдлагад танилцуулав.			√	
47.	Хөдөлмөрийн чадвар алдалтын 2021 оны тоон мэдээллийг улсын хэмжээнд аймаг, сум, дүүрэг, хороогоор гарган олон нийтэд танилцуулав. Мөн энэхүү мэдээллийг АТГ-т хүргүүлэв.			√	
48.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик, мэдээллийн сангийн үйл ажиллагаа идэвхижүүлэх зорилгоор Ажлын хэсэг байгуулж ажиллах удирдамжийг боловсруулж, Хөдөлмөр нийгмийн, хамгааллын яамны холбогдох газарт танилцуулж, ажлын хэсэгт орж ажиллах албан хаагчийн нэрийг авч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ны А/107 тоот “Салбарын статистик, мэдээллийн сангийн үйл ажиллагааг идэвхижүүлэх тухай” тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажиллах удирдамжийг батлуулж ажлын хэсгийн гишүүдэд тушаалыг хүргүүлж, 6 дугаар сард багтаан яамны газар, хэлтэс, харьяа агентлагтай уулзалт зохион байгуулж ажиллах төлөвлөгөөг боловсруулав.			√	
49.	Шинэчлэн боловсруулсан хүүхдийн статистикийн аргачлалыг хэлэлцэх хурлыг дэд ажлын хэсгийн хүрээнд зохион байгуулсан. Уг хурлаар шинэ аргачлалд Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар дахин хянаж, эцэслэн сайдын зөвлөлөөр оруулж, Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, хүргүүлэхээр болсон.			√	
50.	Залуучуудын статистикийн маягт шинэчлэх ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, агентлагийн залуучуудын газартай хамтран дэд ажлын хэсгээр хуралдаж, анхан шатны бүртгэлийн маягт, бүртгэлийн нэгтгэл маягт, захиргааны маягууд боловсруулж, өмнөх батлагдсан маягттай харьцуулсан танилцуулга хийсэн. Уг маягыг аймаг, дүүргийн залуучуудын төвүүдэд туршсаны дараа Үндэсний статистикийн хорооны залуучуудын статистик хариуцсан албан хаагчтай санал солилцож, Үндэсний статистикийн хорооны Аргазүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлд хүргүүлэхээр тохирсон.			√	
51.	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэх дэд ажлын хэсгийн хуралдаанд оролцож ажлын төлөвлөгөө болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн тайлан, мэдээний маягтад санал өгөв.			√	
52.	Сангийн яамны мөчлөг сөрсөн санхүүжилтийн хүрээнд Азийн хөгжлийн банкинд 2021 оны дараах мэдээллийг гаргаж өгч ажиллав. <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын мэдээлэл, хүйсээр • Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, хүйсээр • Нийгмийн халамжийн мэдээлэл, хүйсээр • Хүүхэд харах үйлчилгээ, хүйсээр 			√	
53.	Цахим хуулиуд 5 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд хүний биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээний мэдээллийг бүртгэж, хадгалж байсан систем, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл болон гарын хурууны хээний мэдээллийг устгах ажлыг зохион байгуулав.			√	
54.	Нийгмийн халамж, даатгалын 2019-2022 оны 4-р сарын мэдээний хүснэгтийг боловсруулсан.			√	
55.	Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамтай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн магадлах комиссын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулав.			√	
56.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хүргэх явц, түүний хяналт үнэлгээг бэхжүүлэх сургалт”-ыг цахимаар болон танхимаар 2022 оны 6 дугаар сард зохион байгуулахаар ажиллаж байна.			√	
57.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, холбогдох хуулиудын шинэчлэлийн төсөлд төрийн бус байгууллагуудын саналыг тусгах, хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 тушаалаар байгуулсан. Дэд сайдын ахалсан ажлын хэсэг нь:			√	

	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний бусад улсын туршлагыг судлах; Монгол Улсын нөхцөл байдалд нийцэх туршлагыг тодорхойлох; Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл; болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл <p>Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулиудын төслийг дээрх ажлын хэсгийн дэд ажлын хэсгүүдэд танилцуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын төлөөллийн санал, хүсэлтийг сонсож, хэлэлцүүлгүүдийг хийж байна.</p>				
58.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын тайланг НББХ-ны гишүүдэд 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдөр танилцуулав.		√		
59.	Төрийн аудитын газруудын албан хаагчдыг чадавхижуулах “Нэгдсэн сургалт-2022”-ыг цахимаар зохион байгуулж байгаа бөгөөд уг арга хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр оролцож “Нийгмийн хамгаалал-халамжийн бодлого, үр нөлөө” сэдэвт хэлэлцүүлэгт мэдээлэл хийж оролцов.			√	
60.	Дорноговь аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээрийг хянаж, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх журам”-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн харьяа аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх албан бичгийг хүргүүлэв.			√	
61.	Монгол Улсын Засгийн газраас нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын 2022 оны улсын төсөвт тодотгол хийсэнтэй холбоотойгоор төрийн үйлчилгээ (нийтлэг)-ний бусад албан хаагчдын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох нөхцөл бүрдсэн тул уг албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
62.	Сангийн яам, Төрийн албаны зөвлөл болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг холбогдох тооцоо, судалгаа, ажлын байрны шинжилгээний хамт ирүүлсэнийг судлан үзэж, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
63.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 03 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын үндсэн цалингийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хоёр дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
64.	Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж урамшуулал олгох боломж бүрдүүлэх, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээний схем зэргийг нарийвчлан тодорхойлох аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах зохицуулалтыг бий болгох хүрээнд Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв дэх хэсэг (Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал)-т өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
65.	Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д төрийн үйлчилгээний албан хаагчид уг нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэгдүүлэн тогтоосон үндсэн цалинг бус Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн албан				

	хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг баримтлан олгох нэмэлт, өөрчлөлтийг оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
66.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 92 дугаар зүйлд заасан “Уртын ээлжээр ажиллуулах” зохицуулалтын хэрэгжилттэй холбоотойгоор уул уурхайн салбарын ажил олгогч, ажилтны төлөөллүүдтэй уулзаж тулгамдаж буй асуудлын хүрээнд холбогдох тооцоо, судалгаа бэлтгэн удирдлагуудыг мэдээллээр хангав.			√	
67.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хөдөлмөрийн маргаан зохицуулалтын талаар аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, албаны дарга, хөдөлмөрийн харилцаа хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 10-11-ний хооронд зохион байгуулав. Сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 60 албан хаагчийг хамруулав.			√	
68.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 142 дугаар зүйлийн 142.4-т “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”, 142.9-д “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тус тус заасан. “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”-ийг батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төслийг боловсруулан холбогдох яамд, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад төрийн байгууллагад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсрууллаа.			√	
69.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулахаар ажлын удирдамж болон дүнгийн хүснэгтийн төслийг боловсруулан санал авахаар 2022 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 03/1395 дугаар албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэв.			√	
70.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн эмхтгэлийг боловсруулан, хэвлүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.			√	
71.	-Орон нутагт /аймгуудад/ эмэгтэйчүүдийг чадавхижуулах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан, төсвийн тооцоог хийж Төрийн нарийн бичгийн даргын 2022.05.20-ны өдрийн А/105 тушаалаар батлан, уг ажлыг 5-р сарын 23-наас 6-р сарын 10-ны хооронд гүйцэтгүүлэхээр “Хувь хүний хөгжлийн алсын хараа институт ТББ-тай гэрээ байгуулав. -Нийслэлийн 9 дүүрэгт эмэгтэйчүүдийг чадавхижуулах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан, төсвийн тооцоог хийж, Төрийн нарийн бичгийн даргын А/104 дүгээр тушаалаар батлан, уг ажлыг гүйцэтгүүлэхээр “Импакт медиа групп ХХК-тай гэрээ байгуулав.			√	
72.	-Олон улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан Гэр бүлийн өдрийн мэндчилгээг бэлтгэж сайтад байршуулсан. Мөн ГБХЗХГ болон МЭХ-той хамтран 5-р сарын 13-нд зохион байгуулсан “Гэр бүл-хамтын үүрэг” нээлттэй хэлэлцүүлэгт Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулгыг бэлтгэж оролцсон. -НҮБ-д хүргүүлэх “Эмэгтэйчүүд хөгжилд” үндэсний тайланг бэлтгэн, орчуулж байна.			√	
73.	-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийн дагуу үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий нийгмийн ажилтнуудын албан хэрэгцээнд зориулсан “Кейс шийдвэрлэлт”-ийг эмхэтгэсэн хэрэглээний гарын авлага боловсруулах болон “Эрэгтэйчүүдэд зориулсан нийгэм, сэтгэл зүйн цогц үйлчилгээг тодорхойлох, үйлчилгээний арга зүй, аргачлал” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу ажлыг эхлүүлээд байна. -Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй болгоход чиглэсэн удирдамжийг боловсруулж, ХНХ-ын Сайдын тушаалаар батлуулахад бэлэн болголоо. -“Бэлгийн хүчирхийлэл ба хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний гэр бүлийнхэнд зөвлөгөө өгөх арга зүй” гарын авлагын талаарх хэлэлцүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулж байна. -Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, АНУ болон Монгол Улсын хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд боловсруулах			√	

	сургалтын арга зүйн гарын авлага, удирдамж, бусад баримт бичиг болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнд санал өгөх, сайжруулах чиг үүрэг бүхий техникийн ажлын хэсгийн хуралдааныг зохион байгууллаа.				
74.	-Хорих ангиас суллагдаж буй залуучуудын бие даан амьдрах чадварыг дэмжих хөтөлбөр эцэслэгдэж, 5 дугаар сарын 6-ны өдрийн 1/1258 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Тус салбарт дахин хэлэлцэгдсэнээр жишиг хөтөлбөр эцэслэж, ХНХ-ын Сайд, ХЗДХ-ийн Сайдын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болсон. -Асрамж, халамжийн төвөөс насанд хүрч бие даан амьдрахаар гарч буй залуучуудыг дэмжих хөтөлбөрийн төслийг асрамж, халамжийн төвүүд, аймаг, дүүргийн ЗХТ-ийн ажилтнуудад хэлэлцүүлж, саналыг тусган эцэслэсэн. ХНХ-ын Сайдын тушаалаар 6 дугаар сарын 3-ны өдрийн дотор батлуулахаар төлөвлөж байна.			√	
75.	Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж хуралдааны хөтөлбөрийн хамтаар Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын албанд хүргүүлж, хуралдааны товыг хүсээд байна. Хуралдааны бусад бэлтгэлийг хангаж байна.		√		
76.	Залуучуудын хөгжлийн төв /ЗХТ/-ийн үйлчилгээний стандарт, аргачлал, арга зүйн зөвлөмжийг боловсруулах, залуучуудын статистикийн аргачлал, маягтыг боловсруулах зөвлөх үйлчилгээг тус тус эхлүүлээд байна. Залуучуудын статистикийн аргачлал, маягтыг сайжруулан боловсруулж, төслийг Төв аймаг, Баянзүрх дүүргийн ЗХТ-д 5 дугаар сарын 30-ны өдрөөс 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд туршиж байна. Аргачлал, маягтыг эцэслэсэнээр Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн хурлаар 6-р дугаар сард багтаан хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна. Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний аргачлалын төслийг боловсруулсан бөгөөд стандартыг шинээр боловсруулах, стандарт ба аргачлалыг уялдуулах, стандартыг дагаж гарах журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна			√	
77.	БНСУ-ын КОИКА, НҮБХХ-тэй хамтран "Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх нь" төслийн эхний санхүүжилт хийгдсэнтэй холбогдуулан сургалтын гарын авлагыг хэвлүүлэх, Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх зэрэг ажлыг 6 дугаар сард багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж, бэлтгэлийг хангасан.			√	
78.	Монгол Улс НҮБ-ын GenU санаачилгад нэгдэхтэй холбогдуулан тус санаачилга болон Decent Jobs for Youths санаачилгын зарим зорилт, агуулга давхцаж буйг харгалзан эдгээр санаачилгад зэрэг нэгдэх үүднээс улс орны үнэлгээг хийж байна. Үнэлгээний тайлангийн төсөл, дүгнэлт, бусад улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх сайн туршлагын талаарх танилцуулгын үнэлгээг гүйцэтгэгч "ND Consulting" судалгааны институт 5 дугаар сарын 19-ний өдөр танилцуулсан. Тус яамны ГБХЗГ, ХЭБХЗГ болон ГХАОНХХ, ГБХЗХГ-ын төлөөлөл уулзалтанд оролцож, дүгнэлт, тайлангийн төсөлд санал тусгалаа.			√	
79.	Олон улсын "Найрамдал-2" зуслан байгуулах асуудлаар: • Зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулав. • Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах албан бичгийг БОАЖЯ, Хөвсгөл аймгийн УТХГНутгийн хамгаалалтын захиргаанд тус тус хүргүүлсэн. • Цахилгааны техникийн нөхцөл олгох хүсэлтийг Эрчим хүчний яаманд хүргүүлсэн.			√	
80.	МАОЭНХ, МҮХАҮТ, МҮЭХ-той байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг албажуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэв.			√	
81.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зөвлөмжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг эцэслэн англи хэл рүү орчуулж байна.			√	
82.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн тайланг боловсрууллаа.			√	
83.	Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын зургаа дахь удаагийн ээлжит тайланд хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайланг боловсрууллаа.			√	

84.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбар комиссын гишүүдийн нэгдүгээр улиралын урамшууллыг бодож салбар комиссын хурлаар орсон хүүхдийн тоо мэдээллийг нэгтгэв. Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамуудтай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн мэдээллийн сангийн мэдээлэл солилцох хүрээнд тус салбарын мэдээллийн санг ажлуулж буй салбарын албан хаагчтай уулзалт зохион байгуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн мэдээллийн сангийн мэдээлэл солилцох хүрээнд Чингэлтэй дүүргийн салбар комиссын хуралдаан мэдээллийн сангийн ажлыг хийж буй компанийг оролцуулав. ЯХИС-ийн Хүүхэд бүрийг боловсролд хамруулах зарчмыг дэмжих нь төслийн хүрээнд Ховд, Өвөрхангай аймаг дахь Салбар комисс, Төрөлжсөн мэргэжлийн баг, сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүдийн чадавх бэхжүүлэх уулзалт-хэлэлцүүлэгт оролцов. Уг арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого , үйл ажиллагаа сэдвээр танилцуулга хийж, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэв. Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 60 гаруй албан хаагчдад “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг зохион байгууллаа. 				
85.	ЗГ ын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын төлөөлөлтэй уулзаж, уналт таталтын эсрэг эмийн чанар, хангамжийн тулгараад байгаа асуудлуудыг танилцуулж, санал солилцон, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцав. Энэ ажлын үр дүнд тус агентлагаас эм ханган нийлүүлэх байгууллагуудтай шуурхай уулзалт зохион байгуулсан бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүсч буй уналт таталтын эсрэг чанартай шинэ төрлийн эмнүүдийг Монгол Улсад бүртгэх ажлыг даруй зохион байгуулав.			√	
86.	-Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний цогц, нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэхэд чиглэсэн АХБ-ны буцалтгүй тусламжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд Японы Ядуурлыг Бууруулах Сангаас нэмэлт санхүүжилт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай Сангийн яам, Эзийн засаг, хөгжлийн яаманд уламжлав. -Сонгинохайрхан дүүрэгт бизнес төлөвлөгөө боловсруулах сургалт зохион байгуулав.			√	
87.	Иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай, ил тод болгох зорилгоор E-Mongolia системд нийгмийн даатгалын дараах цахим үйлчилгээг холбов. Үүнд: -Цахим эмнэлгийн хуудас, -Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж цахимаар авах, -Жирэмсний болон амаржсаны тэтгэмж цахимаар авах, -Ажилгүйдлийн тэтгэмж цахимаар авах,				√
88.	Аймаг, сумдын нийгмийн даатгалын мэдээллийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд ОУХБ-ын санхүүжилтээр хийх тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр эхлүүлэв.				√